

МИНИЙ НАЙЗ ЛГБТ



ЯЛГАВАРЛАН
ТАДУУРХАЛТЫГ ..
ЗӨТЦӨӨ



Энэхүү гарын авлагын энэ удаагийн хэвлэлийг Америкийн ард түмний дэмжлэгээс бүрдсэн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Азийн сангийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн салбарыг бэхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн хэвлэв. Тус бүтээлд илэрхийлэгдсэн агуулга нь зохиогчийн үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсвэл дээрх агентлаг, сан, байгууллагуудын албан ёсны байр суурь биш болно.

Зураач: Б.Энх-Оюун

Дизайн: Д.Эрдэнэбүрэн (Гонто), Г.Сүрэнхор

Зохиол: А.Марал, Б.Хулан

“Миний найз ЛГБТ” комик

Энэхүү гарын авлага нь Монгол улсын зохиогчийн эрхийн хуулиар хамгаалагдсан ба зөвшөөрөлгүйгээр хэвлэн нийтлэх, олшруулах, ашиглахыг хориглоно. Номын талаарх санал, сэтгэгдэл хэлэх болон ашиглах зөвшөөрөл авах тохиолдолд ЛГБТ Төв ТББ-тай холбогдоно уу.

© ЛГБТ Төв ТББ

Цахим хаяг: info@lgbtcentre.mn

Цахим хуудас: www.lgbtcentre.mn

Утасны дугаар: 70110323

www.lgbtcentre.mn

МИНИЙ НАЙЗ ЛГБТ





Хүн бие болон сэтгэлийн хувьд аль нэг хүйсийн хүнд татагдаж дурлахыг хүний бэлгийн чиг баримжаа гэдэг ба **хүн бүрд бэлгийн чиг баримжаа бий.**

Кам аут- өөрийгөө ЛГБТИК+ хүн гэдгээ хэн нэгэнд илэрхийлэх



Би стрэйт юм байна.

-Эсрэг хүйсийн хүмүүст татагдах бэлгийн чиг баримжааг гетеросексуал буюу стрэйт.

-Ижил хүйсийн хүмүүст татагдах бэлгийн чиг баримжааг гомосексуал буюу гей/лесбиян.

-Аль аль хүйсийн хүмүүст татагдах бэлгийн чиг баримжааг бисексуал.

Хүмүүс соёл, шашин, арьсны өнгө, гарал үүсэл, нүд, үсний өнгө зэрэг олон мөн чанараараа ялгаатай байдаг шиг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаараа ч мөн ялгаатай ба энэ нь төрөлхийн мөн чанар юм.

Хүйсийн баримжаа, илэрхийлэл гэж юу вэ?

Хүн бүрд өөрийн хүйсээ эмэгтэй, эсвэл эрэгтэй гэж мэдрэх гүн гүнзгий, төрөлхийн зөн совин, мэдрэмж байдаг ба энэ мэдрэмжийг **хүйсийн баримжаа**, харин үг яриа, үйл хөдлөл, хувцаслалт гэх мэт гадаад хэлбэрийг нь **хүйсийн илэрхийлэл** гэдэг.

Өөрийгөө эмэгтэй, эсвэл эрэгтэй гэж мэдрэх мэдрэмж төрөхөд тэмдэглэгдсэн хүйстэй нь нийцдэг хүнийг сизжендэр, харин өөрөөр буюу эсрэгээр байвал трансжендэр гэдэг.

Хүйсийн баримжаа, илэрхийлэл нь хүн бүрд бий. Трансжендэр хүмүүс сизжендэр хүмүүсийн адил гурван төрлийн бэлгийн чиг баримжаатай байдаг.

Зөвлөгөө: Тухайн хүн өөрийгөө чамд трансжендэр гэдгээ илэрхийлсэн л бол өөрийгөө мэдэрч буй хүйсээр нь хүлээн авч, дуудаж бас бусдад илэрхийлээрэй :)

Интерсекс гэдэг нь эр эсвэл эм хүйсийн хэвшмэл ойлголтод багтдаггүй хүйсийн шинж тэмдэгтэй төрсөн хүнийг хэлдэг. Интерсекс шинж тэмдэг нь хүний бие организмын ялгаатай байдлын энгийн, биологийн илрэл юм. Интерсекс байдал олон янзаар илэрч болно.

Бүх интерсекс хүмүүсийн интерсекс шинж тэмдэг төрөхөд нь, эсвэл нялхад нь илэрдэггүй. Интерсекс байдал эхийн хэвлийд, анх төрөхөд, бэлгийн бойжилт эхлэхэд, эсвэл насанд хүрсний дараа илэрч болдог. Хүйсийн анхдагч хүйсийн шинж чанар буюу бэлэг эрхтэн (шодой, үтрээ, сав, хөх гэх мэт) болон хоёрдогч бэлгийн шинж чанар буюу бэлгийн булчирхай (гонад) болон хромосомын хувьд хоёр туйлт хүйсийн ангилалд (эр ба эм) багтдаггүй хүмүүсийг хэлнэ.

Бэлгийн чиг баримжаа болоод хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд цөөнх хүмүүсийг нийтэд нь ЛГБТИК+ эсвэл Күйир гэдэг.



-ЛГБТИК+ хүмүүс хэр их байдаг вэ?

- Күйр хүмүүс таны бодож байгаа шиг ховор, содон зүйл биш. **Күйр хүмүүс аль ч нийгэмд бүхий л цаг үед оршсоор ирсэн.** Чухам өөрийгөө нээлттэй илэрхийлэх боломж байна уу гэдгээс л хамаарах асуудал. Яг хэдэн ЛГБТИК+ хүмүүс байгаа гэдгийг нарийн хэлэх боломжгүй. Гэсэн хэдий ч ямар ч нийгмийн 10 хүртэл хувийг күйр хүмүүс эзэлдэг гэсэн олон улсын жишиг тоо бий



Харин күйр хүмүүс өөрсдийн бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжааны талаар хэр нээлттэй байх нь ихэвчлэн тухайн оронд хүний эрхийг хэр хэмжээнд ханган хамгаалсан, ялгаатай байдлыг хэр хүндэтгэн, хүлээн зөвшөөрсөнтэй шууд харилцан хамааралтай. ЛГБТИК+ хүмүүс нээлттэй амьдрах эсэх нь тухайн орны хөгжил гэхээсээ илүү тухайн орны хүн бүрийн эрх тэгш хамгаалагдах нөхцөл, орчин бүрдсэн эсэхээс хамаардаг. **Таны найз мэдээж ганцаараа биш.**



-Найз минь ЛГБТИК+ учир бусад хүмүүс намайг ч бас ингэж бодох болов уу?

- ЛГБТИК+ найзтай байснаас үүдэн хэн нэгний бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа өөрчлөгдсөн явдал байдаггүй. Чамайг ЛГБТИК+ хүнтэй найзалдаг учир хүмүүс найзыг чинь гадуурхахдаа чамайг ч давхар гадуурхах эрсдэл бий. **ЛГБТИК+ хүмүүсийн хүний эрхийн талаар мэдээлэлтэй байж, найзыг чинь болон чамайг гадуурхах үед хүмүүст зөв мэдээлэл өгөхөд бэлэн байгаарай.**



-Тэгвэл би хүмүүст юу гэж хэлэх ёстой вэ?

-Хүмүүст зөв мэдээлэл өгөх нь чухал ч эхлээд өөрөө зөв зүйтэй мэдээлэлтэй болох нь бүр чухал. **Шинжлэх ухаанч, үнэн зөв, баттай эх сурвалж дээр суурилсан мэдээлэл мөн эсэхийг сайн нягтал гэж зөвлөж байгаарай.**

Шинжлэх ухааны хувьд 1990 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өвчин биш гэдгийг хүлээн зөвшөөрч өвчний ангиллаас албан ёсоор хассан. 2018 онд транс байдлыг мөн тус ангиллаас хассан. **Хэн нэгнийг хайрласныхаа төлөө эсвэл өөрийгөө хэн гэж мэдэрснийхээ төлөө хэн ч бусдад гадуурхагдаж, хүчирхийлэлд өртөх ёсгүй.**





-Хэрвээ манай найз шиг хүмүүсийг бусад хүмүүс гадуурхвал яах вэ?

-Ихэнх хүмүүс мэдэхгүй зүйлээсээ айж, худал мэдээлэлд итгэж бие биенээ гадуурхаж, дээрэлхэж үзэн яддаг. Тэгэхээр тэдэнд эхлээд зөв мэдээлэл өгөх хэрэгтэй. 2017 оны 7-р сарын 1-с эрүүгийн шинэ хуулийн 14.1-т зааснаар...



14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах

1. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.



-Би тусалмаар байна. Яаж туслах вэ? Над шиг стрэйт, сиз дэмжигчид хэр их байгаа вэ?

-Дэмжиж, ойлгодог олон хүний эрхийн хамгаалагчид бий. Ойр орчмын хүмүүстээ зөв мэдээлэл өгч байгаарай.



-Манай найз маш ичимхий, бусад хүмүүст өөрийгөө илэрхийлэхээс айж байгаа юм шиг санагдсан.

-Өөрийгөө илэрхийлэхэд бэлэн биш эсвэл ойрын хүмүүс нь өөрийг нь үгүйсгэх вий гэдэг айдастай байж магадгүй. Тэглээ гээд өөрийнх нь өмнөөс бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааг нь бусдад дур мэдэн илэрхийлж болохгүй шүү.



-За баярлалаа. Амжилт хүсье !

Маргааш нь найзуудтайгаа
сонссон мэдээллээ хуваалцахад :

Чи уруу татагдаад байгаа юм биш
vv?

Их явдалтай гэдэг үнэн болов уу?

-Тэд сонголтоороо "тийм"
болчихдог биз дээ?
Би сэтгэцийн өвчнөөс болж
ЛГБТ болдог гэж сонссон?

Ер нь эрэгтэйлэг охидууд,
эмэгтэйлэг хөвгөөд л байвал
ЛГБТ гэсэн үг биз дээ

Тэгээд хvvхэдтэй болж
чадахгvi биз дээ?



ЛГБТИК+ байх нь сонголт биш, харин үзэн ядах, үгүйсгэх нь сонголт. Аав ээж, эх орноо сонгож төрдөггүйтэй адил бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаагаа сонгож төрдөггүй. Хүн өөрийнхөө мөн чанарыг хэдэн ч насандаа мэдэрч, мэдэх бас илэрхийлэх боломжтой. **Бас уруу татна гэдэг зүйл байхгүй**, би үнэн зөв мэдээллийг л бусдад түгээж байна.

Эрэгтэйлэг охин лесбиян, эмэгтэйлэг залуу гей гэдэг бол хэмшмэл ойлголт. Хүн бүр өөр өөр, бүгд ялгаатай. Бүгдийг нэг хэвэнд цутгаж сэтгэх нь их баригдмал сэтгэлгээтэй байгаа гэсэн үг. Стрэйт хүмүүст дунд ч бас олон янзын хүмүүс байдгийг бүгд мэднэ шүү дээ, бүх ЛГБТИК+ хүмүүс адилхан биш ээ.

Орчин үед ижил хүйсийн хосууд хүүхэдтэй болох олон арга бий.




ААН.



- Монголд ЛГБТИК+ хүмүүсийн тэгш эрхийн төлөөх хөдөлгөөн өрнөсөөр байгаа нь ЛГБТИК+ хүмүүсийн хүний эрх зөрчигдсөөр байгаатай шууд холбоотой.

Хүн болж төрснийхөө хувьд бүгд тэгш эрхтэй ч, харамсалтай нь ялгаатай байдлаасаа болж гадуурхагдах тохиолдол түгээмэл байдаг. Худал, буруу мэдээлэл, хэвшмэл ойлголтоос болж нийгэмд цөөнх болсон хүмүүс эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадахгүй байгаа. Энэ шударга бус дүр зургийг зүгээр суугаад тэвчихгүй, тэгш эрхийн төлөө дуу хоолойгоо өргөн өөрийгөө болон бусдыг хүн гэдэг утгаар нь хүлээж авч байгаагаа илэрхийлж, тэмцэж

байгаагаараа бахархаж байгаа юм болов уу. Хүн бүр бахархлын тал дээр өөр өөр ойлголттой байх л даа. Миний хувьд өөрийгөө бүрэн хүлээн зөвшөөрч, күйр гэдгээ нуудаггүйгээрээ бахархдаг



Сайн уу?

Бид нартай
суух уу?



- Сайн уу, намайг Ананд гэдэг. Би 16 настай бисексуал, үүнийгээ гэрийнхэндээ хэлээгүй ч бүх найзууд маань мэддэг зөвөөр хүлээж авдаг нь баярладаг. Күйр хүүхдүүд гэхээсээ дандаа стрейт хүүхдүүдтэй нийлдэг болохоор тулгарсан асуудлыг чинь ойлгож байна. Гэхдээ хамгийн сайн найз чинь мөн л бол чамайг 100% ойлгоно оо, надад итгээрэй хэхэ. Бас би одоо найз залуутай ба түүнтэйгээ үерхээд 6 сар болж байна. Бид 2 бие биедээ маш их хайртай, тэр маань намайг бисексуал гэж мэддэг.



Сайн уу? Намайг Хулан гэдэг. ЛГБТИК+ хүний эрхийг дэмжих үйл ажиллагаанд нэгдэж, оролцоогоо нэмэгдүүлэхийг хичээдэг сизжендер, стрэйт залуусын төлөөлөл. Ихэнх дэмжигчдийн хувьд “Хэрвээ би ийм үйл ажиллагаанд оролцвол хүмүүс намайг юу гэж бодох бол?” эсвэл “Буруу зүйл сурталчиллаа гэж буруушаах болов уу?” мэтчилэн нийгэмд яаж харагдах бол гэсэн айдастай байдаг. Түүнчлэн хаанаас яаж эхэлж, хэрхэн нэгдэхээ мэдэхгүй, эсвэл заримдаа өөрөө ч мэдээгүй байхдаа буруу мэдээлэл түгээсэн байх магадлалтай байдаг.

Хүн бүрийн нас хүйс, зан ааш, гадаад төрх, төлөвшилт, хүмүүжил, боловсролын байдал, санхүүгийн бололцоо харилцан адилгүй ч нэгэн Дэлхийд мөр мөрөө түшилцэн суугаа хойно биднийг нэгтгэх адил зүйлүүд олон бий. Бид бүгдээрээ хайрлах болон хайрлагдах эрхтэй, өөрийнхөөрөө байх эрх чөлөөтэй. Хэнийг хайрласнаараа буруутгагдаж, сэтгэлийн асуудлаа бусдад шүүлгэх нь хамгийн шударга бус юм. Зөрчлийн асуудлыг зогсоохын тулд хүн бүр бие биенээ хүндэтгэж, зөв зүйлсийг үлгэрлэх нь зүйтэй.

- Сайн уу? Намайг Бямбаа гэдэг. Би 19 настай. Трансжендэр эрэгтэй. Бас найз охинтой. Үерхээд жил гаруй хугацааг ардаа үдэж байна. Анх найз охиндоо өөрийгөө трансжендэр гэдгээ хэлээгүй. Намайг орхичих болов уу гэж айсандаа. Гэхдээ транс хүмүүст байдаг хүйсийн тавгүйцлээс болж тэр минь мэдсэн. Би өөрийгөө толинд харах бүрдээ өөрийнхөө биеийг үзэн яддаг, эхээс төрсөн бие, хоолойноосоо болж гадуур хамаагүй инээж, хөөрөөд явж чаддаггүй. Хамгийн аймар нь бүх л зүйл намайг тавгүйцэхэд хүргэдэг байсан. Харин одоо бол найз охиныхоо ачаар өөртөө илүү итгэлтэй болж байгаа. Бас маш сайн аав болно гэж боддог болсон. Бүх хүмүүс ЛГБТИК+ хүмүүсийг ойлгохоос илүүтэйгээр хажуудах ойр дотны хүмүүс нь илүү их мэдэрдэг байгаасай.



ТЭГШ ЭРХ, БАХАРХЛЫН ӨДРҮҮДЭЭР



Трансгендер хүмүүсийн эрхийг хангах зохицуулалт:

Иргэний улсын бүртгэлийн тухай хууль

14 дүгээр зүйл. Хүйс өөрчлөгдсөний бүртгэл

14.1. 18 нас хүрсэн иргэн хүйсээ өөрчилснийг иргэний улсын бүртгэлд бүртгүүлэх бол дараах баримт бичгийг бүрдүүлж, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өөрийн биеэр бүртгүүлнэ:

14.1.1. өргөдөл;

14.1.2. иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ;

14.1.3. эмнэлгийн байгууллагаас хүйс өөрчлөгдсөнийг нотолсон баримт бичиг.

14.2. Энэ хуулийн 14.1-д заасан баримт бичигт дараах баримт бичгийн аль тохирохыг хавсаргана:

14.2.1. гэрлэлт дуусгавар болсон тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

14.2.2. хүүхдийн эцэг /эх/-ийн нэрийн бүртгэлд өөрчлөлт оруулах бол эцэг /эх/-ийн өргөдөл;

14.2.3. хүүхдийн төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх.

14.3. Улсын бүртгэгч энэ хуулийн 14.1, 14.2-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор хүйс өөрчлөгдсөний бүртгэлийг хөтөлнө.

Мөн түүнчлэн дараахь албан хаагчдын ёс зүйн дүрэмд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээр ялгаварлан гадуурхахгүй байх талаар зааж, мөрдөгдөж байна.

Эдгээрт:

- Эмнэлгийн мэргэжилтэн нь үйл ажиллагаандаа шударга ёс, хууль дээдлэх, тэгш байдал, үл ялгаварлан гадуурхах, хариуцлага хүлээх, үйлчлэх зарчмыг баримтална (Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11-р сарын 25-ны 446-р тушаалын 1-р хавсралт) Үл ялгаварлан гадуурхах гэж Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т зааснаас гадна төрх байдал, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, хүн амын тодорхой бүлэгт харьяалагдах байдлаар алагчлахгүй байхыг (Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ)
- Иргэдийн эрүүл мэндийн байдал, өвчин эмгэгийн төрөл, оршин суугаа газар, нас, хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, хэл

соёлын ялгаанаас үл хамааран тэгш, хүртээмжтэй хүргэх (Тулгуур зарчим, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодлого батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2014 оны 2-р сарын 24-ний өдрийн 55-р тушаалын хавсралт)

- Эрүүл мэндийн яам: 2013, 2014 онд салбарын хөгжлийн бодлого болон салбарын мэргэжилтний ёс зүйд ялгаварлан гадуурхалтын эсрэг зарчмыг багтаасан.
- Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм (Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 288 дугаар тогтоолын хавсралт, 5 дугаар зүйлийн 5.2.3-т зааснаар)
- Цагдаагийн албан хаагчийн ёс зүйн дүрэм (Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны 598 дугаар тушаалын хавсралт, 4 дүгээр зүйлийн 4.1.2-т зааснаар)
- Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим (Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралт)
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм (Ерөнхий байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх гэж заасан)

Өөрийн болон ах, эгч, дүүгийнхээ бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай илүү ойлголттой болохыг хүсэж буй хүмүүс, мөн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээс үүдэн хүний эрх нь зөрчигдсөн тохиолдолд сэтгэл зүйн болон эрх зүйн туслалцаа авахаар хандах нь маш их.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд төрийн болон төрийн бус байгууллагууд, мөн хувийн хэвшлийн байгууллагууд өөрсдийн үйлчлүүлэгчид болон ажилтнуудын ялгаатай байдалд мэдрэмжтэй хандах зорилгоор мэдээлэл болон сургалт авах нь нэмэгдэж байна.

2019 оноос хойш хувь хүмүүсийн хандиваар сайн дурын ажилтнуудын өрөөтэй болж, олон нийтэд илүү нээлттэй болсон юм.

Монгол ЛГБТИК+ хүмүүсийн бодит түүх, тэдний дурсамж, хайр дурлал, нөхөрлөл гэх зэргийн тухай сонсохыг хүсвэл манай “Mongolian Queer Podcast”-аас хүлээж авна уу. Дараах сувгуудаас хайлт хийн сонсоорой:

- [Soundcloud.com](https://soundcloud.com)
- [Youtube.com](https://youtube.com)
- [Castbox.fm](https://castbox.fm)
- [Apple podcast](https://applepodcast.com)
- [Mplus.mn](https://mplus.mn)

ЛГБТ ТӨВӨӨС ЭРХЛЭН ГАРГАСАН, ОРЧУУЛСАН ГАРЫН АВЛАГА БОЛОН НОМУУДЫГ ОФФИС ДЭЭРЭЭС ИРЖ АВАХ БОЛОМЖТОЙ.

1. Лесбиян, гей, бисексуал Үйлчлүүлэгчидтэй ажиллах удирдамж (Америкийн Сэтгэл Судлалын Нийгэмлэг)
2. Үзэн ядалтын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдэвэрлэх нь
3. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай хэрхэн бичих вэ?
4. Транссексуал, трансжендэр болон хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүмүүсийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт
5. Жогжакартын зарчмууд
6. ЛГБТИК+ олон нийтийн тухай түгээмэл асуугддаг асуултууд
7. ЛГБТИК+ хүний эрх - Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарт зориулсан гарын авлага
8. ЛГБТИК+ хүний эрх - Хүний нөөцийн мэргэжилтэн, байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан гарын авлага
9. “Миний найз ЛГБТ” комик ном
10. Лесбиян хүмүүст хөндөгдөх эрүүл мэндийн 10 асуудал
11. Гей хүмүүст хөндөгдөх эрүүл мэндийн 10 асуудал
12. Бисексуал хүмүүст хөндөгдөх эрүүл мэндийн 10 асуудал
13. Трансжендэр хүмүүст хөндөгдөх эрүүл мэндийн 10 асуудал
14. “Эрхийн төлөө урлаг” уран бүтээлийн каталог, 2019-2024 он
15. “Хайр бол хайр” манга ном
16. Амьдрал Эрх чөлөө Хайрын магтуу - Дэлхийн шилдэг ЛГБТ яруу найргийн түүвэр
17. “Homo Liber” эсээ түүвэр
18. Транс* олон нийтийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар эрүүл мэндийн мэргэжилтнүүд болон транс* олон нийтийн мэдлэг, хандлагын судалгаа
19. Транс* байх нь



ЛГБТИК+ ХҮМҮҮСИЙН ТЭМДЭГЛЭДЭГ ОЛОН УЛСЫН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮД ЮУ ЮУ БАЙДАГ ВЭ?

- 2-р сарын 14-өөс эхлэх 7 хоног. Аромантик байдлыг ойлгох 7 хоног.
- 3-р сарын 01-ний өдөр. Zero discrimination day / Ялгаварлан гадуурхалтгүй өдөр
- 3-р сарын 08-ны өдөр. ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр
- 3-р сарын 31-ний өдөр. Транс байдлыг ойлгох олон улсын өдөр
- 4-р сарын 06-ны өдөр. Асексуал байдлын талаар мэдлэгээ тэлэх өдөр
- 4-р сарын 26-ны өдөр. Лесбиян байдлыг ойлгох өдөр
- 5-р сарын 17-ны өдөр. АЙДАХОТБ-Олон улсын Гомофоби, Бифоби, Трансфобийн Эсрэг Өдөр
- 5-р сарын 24-ний өдөр. Пансексуал байдлыг ойлгох өдөр
- 6-р сар бүхэлдээ. АНУ, Их Британи, Канада, Франц г.м. улсуудад Бахархлын сар
- 7-р сарын 14-ний өдөр. Олон улсын нонбайнари өдөр
- 7-р сарын 06-ны өдөр. Дрэг өдөр
- 8-р сарын сүүлийн Баасан гарагаас эхлэн Монгол дахь Тэгш эрх, Бахархлын өдрүүд
- 9-р сарын 23-ны өдөр. ОУ-ын Бисексуал байдлыг ойлгох өдөр
- 10 сарын 11-ний өдөр. Камин аут буюу өөрийгөө илэрхийлэх өдөр
- 10-р сарын 3 дахь 7 хоногийн Лхагва гарагт Төлөөний үгний өдөр
- 10-р сар бүхэлдээ. АНУ-ын ЛГБТИК+ түүхийн сар
- 10-р сарын 26-ны өдөр. Интерсекс байдлыг ойлгох өдөр
- 11-р сарын 08-ны өдөр. Интерсекс хүмүүсийн гэгээн дурсгалыг хүндэтгэх өдөр
- 11-р сарын 20-ны өдөр. Трансжендэр хүмүүсийн гэгээн дурсгалыг хүндэтгэх өдөр
- 12-р сарын 01-ний өдөр. Дэлхийн ДОХ-ын эсрэг өдөр
- 12-р сарын 10-ны өдөр. ОУ-ын хүний эрхийн өдөр гэх мэт өдрүүд байдаг.



Жич: Энэхүү жагсаалтад ороогүй өдрүүд мөн байгаа болно.

